

Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот

2017 он



ЭРҮҮҮЛ МЭНД

2016 оны байдлаар дүүргийн эмнэлэгт 8151 эх амаржиж 8185 хүүхэд төрсөн нь 2015 онтой харьцуулахад 366 хүүхдээр буюу 4.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-1. Эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Төрсөн эх	6195	7498	7519	7774	8151
Шинээр төрсөн хүүхэд	6918	7561	7577	7819	8185
0-1 насны хүүхдийн эндэгдэл	70	93	102	103	122
1000 амьд хүүхдэд ногдох					
0-1 насны эндэгдэл	10.99	12.30	13.42	13.17	14.90
1-5 насны хүүхдийн эндэгдэл	19	15	18	27	21
1000 амьд хүүхдэд ногдох	2.75	1.98	2.38	3.45	2.60
1-5 насны эндэгдэл					
Эхийн нас баралт	4	3	1	3	4
1000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл	0.58	39.68	13.20	38.37	48.9
Амгүй төрөлт	53	56	50	59	43
Гэрийн төрөлт	24	24	26	28	19
Хяналтгүй төрөлт	27	31	31	22	36
Нийт нас баралт	1420	1414	1362	1369	1294
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	5380	3901	4237	10273	10755
10000 хүнд ноогдох халдварт өвчин	195.89	135.0	141.0	335.00	341.7


0-1 насны хүүхдийн эндэгдэл 2016 онд 122 гарсан нь өмнөх онтой харьцуулбал 19 хүүхдээр буюу 18.4 хувиар өссөн бол 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2016 онд 21 гарч өмнөх оноос 22.2 хувиар буюу 6 хүүхдээр өссөн үзүүлэлтүүд гарчээ.

Эхийн эндэгдэл 2016 онд 4 тохиолдол гарсан бол өмнөх онтой харьцуулахад 1 эхээр буюу 33.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2016 онд 43 амьгүй төрөлт, 19 гэрийн төрөлт, 36 хяналтгүй төрөлт гарсан ба өмнөх онтой харьцуулахад амьгүй төрөлт 27.1 хувиар, гэрийн төрөлт 32.1 хувиар тус тус буурч, хяналтгүй төрөлт 63.6 хувиар өссөн байна.

Нийт нас барсан хүний тоо 1294 хүрч өмнөх оноос 75 хүнээр буюу 5.5 хувиар өссөн байна.


Зураг-1. Амгүй төрөлт, гэрийн төрөлт, Зураг-2. Амаржсан эх, төрсөн хүүхэд, оноор хяналтгүй төрөлт, оноор



Хүснэгт-2. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр

Дүүрэг	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Баянгол	4880	5217	5356	5446	5458
Баянзүрх	6918	7561	7577	7819	8185
Сүхбаатар	3467	3695	3840	3789	3073
Сонгинохайрхан	7264	7798	8596	8331	8209
Хан-уул	3407	3737	4091	4510	4613
Чингэлтэй	4400	4377	4505	4651	4209
Багануур	769	864	782	650	652
Багахангай	92	82	95	75	85
Налайх	930	971	1012	1026	835
Улаанбаатар	32127	34302	35854	36297	35319
Улаанбаатар хотын дүнд Баянзүрх дүүргийн эзлэх хувийн жин	21.5	22.0	21.1	21.5	23.2

Зураг-1. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр




Сүүлийн 5 жилийн байдлаар дүүрэгт жилд дунджаар 7612 хүүхэд төрсөн байна. Улаанбаатар хотод төрсөн нийт 35319 хүүхдийн 8185 нь буюу 23.2 хувь нь Баянзүрх дүүрэгт төрсөн байна.

2016 онд төрсөн 8185 хүүхдийн тоог өмнөх онтой харьцуулахад 4.7 хувиар буюу 366 хүүхдээр өссөн байна.

Төрсөн хүүхдийн тоог сүүлийн 5 жилээр авч үзвэл жилд дунджаар 5.7 хувиар өссөн бол 2012 хамгийн өндөр буюу 11.1 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотын дүнд төрсөн хүүхдийн тоогоор эзлэх хувийн жинг нь ажиглавал 2012 онд 21.5 хувь, 2013 онд 22.0 хувь, 2014 онд 21.1 хувь, 2015 онд 21.5 хувь, 2016 онд 23.2 хувийг эзэлж байна.

Зураг-3. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр



Хүснэгт-1. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд хүүхдэд ноогдох эндэгдэл, дүүргээр

Дүүрэг	2012 он		2013 он		2014 он		2015 он		2016 он	
	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох
Баянгол	33	6.76	49	9.39	56	10.46	53	9.73	48	8.8
Баянзүрх	76	10.99	93	12.30	102	13.46	103	13.17	122	14.9
Сүхбаатар	31	8.94	41	11.10	38	9.90	41	10.82	41	13.3
Сонгино-хайрхан	79	10.88	93	11.93	117	13.61	121	14.52	94	11.5
Хан-уул	37	10.86	48	12.84	45	11.00	41	9.09	44	9.5
Чингэлтэй	53	12.05	49	11.19	53	11.76	49	10.54	50	11.9
Багануур	11	14.30	8	9.26	12	15.35	7	10.77	16	24.5
Багахангай	0	0.00	0	0.00	2	21.05	1	13.33	0	0.0
Налайх	20	21.51	17	17.51	15	14.82	16	15.59	18	21.6

Баянзүрх дүүрэгт 0-1 насны хүүхдийн эндэгдэл 122-т хүрч өмнөх оноос 18.4 хувиар буюу 19 хүүхдээр өссөн байна. Мөн Улаанбаатар хотын 9 дүүрэгтэй харьцуулахад 0-1 насны хүүхдийн эндэгдлийн тоогоор нэгдүгээрт орж байна.

Хүснэгт-1. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд хүүхдэд ноогдох эндэгдэл, дүүргээр

Дүүрэг	2012 он		2013 он		2014 он		2015 он		2016 он	
	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох	Тоо	1000 амьд хүүхдэд ноогдох
Баянгол	8	1.64	8	1.53	6	1.12	6	1.10	6	1.1
Баянзүрх	19	2.75	15	1.98	18	2.38	27	3.45	21	2.6
Сүхбаатар	7	2.02	11	2.98	5	1.30	7	1.85	8	2.6
Сонгино-хайрхан	17	2.34	15	1.92	23	2.68	23	2.76	29	3.5
Хан-уул	6	1.76	9	2.41	13	3.18	5	1.11	12	2.6
Чингэлтэй	13	2.95	12	2.74	12	2.66	4	0.86	11	2.6
Багануур	3	3.90	2	2.31	1	1.28	0	0.00	2	3.1
Багахангай	0	0.00	1	12.20	0	0.00	0	0.00	2	23.5
Налайх	1	1.08	8	8.24	4	3.95	1	0.97	4	4.8

Баянзүрх дүүрэгт 1-5 насны хүүхдийн эндэгдэл 21-д хүрч өмнөх оноос 22.2 хувиар буюу 6 хүүрдээр буурсан байна. Мөн Улаанбаатар хотын 9 дүүрэгтэй харьцуулахад 1-5 насны хүүхдийн эндэгдлийн тоогоор Сонгинохайрхан дүүргийн дараагаар хоёрдугаарт орж байна.

2016 онд халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 10273 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.7 хувиар буюу 482 хүнээр өссөн байна.

Баянзүрх дүүргийн хэмжээнд 10000 хүн амд ноогдох халдварт өвчний тоо 2016 онд 341.70 өмнөх оны мөн үед 335.00 байсан нь 2.0 хувиар буюу 6.7-оор өссөн байна.

Хүснэгт 1. Халдварт өвчин, 10000 хүн тутамд ноогдох халдварт өвчний тоо

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн бүгд, үүнээс:	бодит тоо	5380	3901	4237	10273	10755
	10000 хүнд	195.89	135.00	141.00	335.00	341.70
Вируст гепатит	бодит тоо	498	215	135	138	99
	10000 хүнд	18.13	7.4	4.51	4.50	3.1
Менингит	бодит тоо	2	6	0	1	3
	10000 хүнд	0.07	0.21	0.00	0.03	0.10
Цусан суулга	бодит тоо	456	479	588	696	722
	10000 хүнд	16.60	16.57	19.63	22.71	22.9
Салхин цэцэг	бодит тоо	494	757	750	1142	1327
	10000 хүнд	17.99	26.18	25.03	37.26	42.2
Гахай хавдар	бодит тоо	2064	362	77	56	80
	10000 хүнд	75.15	12.52	2.57	1.83	2.5
Сальмонеллөз	бодит тоо	23	16	20	37	45
	10000 хүнд	0.84	0.55	0.67	1.21	1.4

Баянзүрх дүүргийн эрүүл мэнд-2016 он


Улаан эсэргэнэ	бодит тоо	26	92	96	198	374
	10000 хүнд	0.95	3.18	3.20	6.46	11.9
Хоолны хордлого	бодит тоо	117	37	51	85	147
	10000 хүнд	4.26	1.28	1.70	2.77	4.7
Ёлом	бодит тоо	32	23	30	23	30
	10000 хүнд	1.17	0.80	1.00	0.75	1.0
Бруцеллёз	бодит тоо	58	1	6	5	1
	10000 хүнд	2.11	0.03	0.20	0.16	0.00
Нярайн халдвар	бодит тоо	12	0	2	0	0
	10000 хүнд	0.44	0.00	0.07	0.0	0.0
Гар хөл амны өвчин	бодит тоо	0	361	555	407	1573
	10000 хүнд	0.00	12.49	18.52	13.28	50.00
Тэмбүү	бодит тоо	123	522	633	681	461
	10000 хүнд	4.48	18.06	21.13	22.22	14.6
Заг хүйтэн	бодит тоо	443	133	187	204	191
	10000 хүнд	16.13	4.60	6.24	6.66	6.1
Трихомониаз	бодит тоо	165	359	438	423	359
	10000 хүнд	6.01	12.42	14.62	13.80	11.4
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	335	530	644	580	576
	10000 хүнд	12.20	18.33	21.49	18.92	18.3
Бусад	бодит тоо	532	8	25	5597	4767

2016 дүүргийн хэмжээнд нийт 10755 халдварт өвчин гарсны 90.6 хувь нь буюу 9844 нь цочмог халдварт өвчин үлдсэн 9.4 хувь нь буюу 911 нь бэлгийн замын халдварт өвчин байна.

Цочмог халдварт өвчний тоо 2016 онд 9844-т хүрч өмнөх оноос 10.3 хувиар буюу 919 өвчлөлөөр өссөн байна.

Нийт халдварт өвчний 0.9 хувийг буюу 99 нь вируст гепатит өвчин, 6.7 хувийг буюу 722 нь цусан суулга өвчин, 12.3 хувийг буюу 1327 нь салхин цэцэг өвчин, 0.7 хувийг буюу 80 нь гахайн хавдар өвчин, 0.4 хувь нь буюу 45 нь сальмонеллэз өвчин, 3.5 хувь буюу 374 нь улаан эсэргэнэ өвчин, 1.4 хувь нь буюу 147 нь хоолны хордлого өвчин, 0.3 хувь нь буюу 30 нь ёлом өвчин, 1 нь бруцеллэз өвчин, 14.6 хувь нь буюу 1573 нь гар, хөл, амны өвчин, 4.3 хувь нь буюу 461 нь тэмбүү өвчин, 1.8 хувь нь буюу 191 нь заг хүйтэн өвчин, 3.3 хувь нь буюу 359 нь трихомоназ өвчин, 5.3 хувь нь буюу 576 нь шинээр илэрсэн сүрьеэ өвчин, 44.5 хувь нь буюу 4770.0 нь бусад өвчин эзлэж байна.


Зураг-1. Нийт халдварт өвчин, бүтцээр



Бэлгийн замын халдварт өвчний 45.6 хувь нь буюу 461 нь тэмбүү өвчин, 18.9 хувь буюу 191 нь заг хүйтэн өвчин, үлдсэн 35.5 хувь нь буюу 359 нь трихомониаз өвчин тус тус эзлэж байна.

2016 онд бүртгэгдсэн бэлгийн замын халдварт өвчин 1011-д хүрч өмнөх оноос 77.3 хувиар буюу 197 тохиолдолоор өсчээ.

Зураг-1. Бэлгийн замын халдварт өвчин, бүтцээр



Тэмбүү өвчний гаралт 2016 онд 461-д хүрч өмнөх онтой харьцуулахад 32.3 хувиар буюу 220 тохиолдлоор, заг хүйтэн өвчин 191-д хүрч 6.4 хувиар буюу 13 тохиолдлоор тус тус өсч, трихомониаз өвчин 359-д хүрч 15.1 хувиар буюу 64 тохиолдолоор буурсан байна.


Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл тэмбүү өвчинд ажиглалт хийхэд 2012-2013 оны хооронд 4.2 дахин буурах хандлагатай байсан бол, 2013-2014 оны хооронд 21.3 хувиар, 2014-2015 оны хооронд 7.6 хувиар тус тус өсч, 2015-2016 оны хооронд 32.3 хувиар буцаад буурах хандлага ажиглагдаж байна.

Заг хүйтэн өвчинг сүүлийн 5 жилээр авч үзвэл жилд дунджаар 191 тохиолдол гарч 6.4 хувиар буурсан байна.


Трихомониаз өвчний хувьд 423 тохиолдол бүртгэгдэж сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 19.0 хувь байна.

2016 оны байдлаар дүүргийн нийт хүн амын 0.1 хувь нь буюу 911 хүн тутмын 1 нь бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг-1. Халдварт өвчний тоо, шинээр илэрсэн сүрьеэ өвчин




Зураг-1. Халдварт өвчний тоо, вирус гепатит өвчин




Шинээр илэрсэн сүрьеэ өвчин 2016 онд 576 гарч өмнөх онтой харьцуулахад 4 өвчлөлөөр буюу 0.7 хувиар өссөн бол сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл жилд дунджаар 19.8 хувиар өссөн байна.

Вирус гепатит өвчин 99 болж өмнөх оноос 28.3 хувиар буюу 39 өвчлөлөөр буурсан байна.

Зураг-1. Халдварт өвчин, салхин цэцэг өвчин



Зураг. Халдварт өвчин, цусан суулга өвчин



2016 онд салхин цэцэг өвчин 1327 гарч өмнөх оноос 185 оор буюу 16.2 хувиар, цусан суулга өвчин 722 гарч 26-аар буюу 3.7 хувиар тус тус өссөн байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл жилд дунджаар 894 салхин цэцэг өвчин, 588 цусан суулга өвчин гарсан байна.

Минингит өвчин 2014 онд тус өвчин гараагүй бол тайлант онд буюу 2016 онд тус өвчин 3 гарсан бол гахайн хавдар өвчин 2016 онд 80 тохиолдол гарсан нь 0 өмнөх онтой харьцуулахад 24-өөр буюу 42.9 хувиар өссөн, мөн сальмонеллэз өвчин 2016 онд 45 гарч өмнөх оноос 8-аар буюу 21.6 хувиар, улаан эсэргэнэ өвчин 2016 онд 374 гарч өмнөх оноос 176-аар буюу 88.9 хувиар, хоолны хордлого 2016 онд 147 бүртгэгдэж өмнөх оноос 62-оор буюу 72.9 хувиар, ёлом өвчин 2016 онд 30 гарч өмнөх 7 оор буюу 30.4 хувиар тус тус өссөн бол, бруцеллэз өвчин 2016 онд 1 гарч өмнөх оноос 5-аар буюу 5 дахин буурч, гар хөл амын өвчин 2016 онд 1573 гарч өмнөх оноос 1166-аар буюу 3.8 дахин өсч тус өвчний дэгдэлт нэмэгдсэн байна.

Бэлтгэсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Цэвэлмаа

Хянасан: Хэлтсийн дарга

/Э.Энхтунгалаг/

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС